



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026. 01. 02 № 05-06/05
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГУУДАД**

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай” А/1843 дугаар захирамжийг хүргүүлэв.

Иймд байгууллагууд 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу бэлтгэл ажлыг хангуулна уу.

Хавсралт 19 хуудастай.

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА

Б.МӨНХБАЯР



1726190006



نیشنل سائنس اکیڈمی، اسلام آباد

1735200002



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 11843

Улаанбаатар хот

Байгууллагуудын үйл ажиллагааны
үр дүнг үнэлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот байгууллага, төслийн нэгж, хуулийн этгээдийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар, байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн дотор зохион байгуулж, дүнг танилцуулахыг зохион байгуулах ажлын хэсэг (Т.Оюунчимэг)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725038111



۱۴۰۲/۱۲/۲۲

مستقر مستقر مستقر
 مستقر مستقر مستقر

[illegible][illegible][illegible]

نیکو بیایم از خیر و برکت (مستخرج از حدیث)

۵۔ ذیوسنہ

1725035561

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
72 дугаар сарын 8-өдрийн
14843 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Т.Оюунчимэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга.
Гишүүд:	П.Хадбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
	М.Үнэнбат	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга;
	Л.Эрдэнэбадрах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;
	Ү.Ганболд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
	Б.Солонго	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны газрын дарга;
	П.Нэргүй	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газрын дарга;
	Ш.Анхмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газрын дарга;
	Б.Амирлан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнхбаяр	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 2 өдрийн
17/113 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Зорилго, үндэслэл

1.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төслийн нэгж, хуулийн этгээдийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулж, ажлын зохион байгуулалт, сахилга хариуцлагыг бэхжүүлэн, төрийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

1.2.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ыг тус тус эрх зүйн үндэслэл болно.

Хоёр.Хугацаа

2.1.Үнэлгээний ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал ажлын 11 хоногт гүйцэтгэнэ.

2.2.Үнэлгээ хийсэн ажлын дүнг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор зохион байгуулах Ажлын хэсэгт танилцуулна.

Гурав.Хамрагдах байгууллага

3.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төслийн нэгж, хуулийн этгээд.

Дөрөв.Зохион байгуулалт

4.1.Үнэлгээний ажлыг зохион байгуулах Ажлын хэсэг нь байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн ажлын нэгдсэн дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулна.

4.2.Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийхдээ Үнэлгээний багийн гишүүд багийн ахлагчийн баталсан ажил үүргийн хуваарийн дагуу бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллана.

4.3.Үнэлгээний баг нь байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээний ажлын нэгдсэн илтгэх хуудас үйлдэх бөгөөд илтгэх хуудаст үнэлгээний багийн ахлагч болон гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулан зохион байгуулах Ажлын хэсэгт ажлаа тайлагнана.

4.4.Үнэлгээний бодит байдлыг тухайн Ажлын хэсэг хариуцна. Үнэлгээ хийсэн тухай илтгэх хуудаст байгууллагуудаас тухайн жилд хийсэн ажлын ололт амжилт, алдаа дутагдал, анхаарах зүйлс, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар

тусгаж, үнэлгээ хийгдсэн байгууллага тус бүрийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу хүснэгтэн мэдээллээр гаргаж хавсаргана.

4.5. Үнэлгээний багийн гишүүнээр томилогдсон албан хаагчийг ажиллах боломжоор хангах үүргийг тухайн албан хаагчийн ажилладаг байгууллага, нэгжийн удирдлага хүлээнэ.

4.6. Байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд онцгой анхаарах чиглэл:

- Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилт, үр дүн;

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн “2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны биелэлтийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал, үр дүн;

- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн;

- Нийслэлийн тухайн жилийн зорилтод жилийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн;

- Нийслэлийн Засаг даргатай байгууллагын дарга нарын байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний биелэлт, үр дүн;

- “Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний биелэлт, үр дүн;

- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлтийн оновчтой байдал, гүйцэтгэл, чанар, үр дүн;

- Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;

- Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;

- Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал;

- Ажилтан, албан хаагчдын мэдлэг, боловсролыг хөгжүүлэх сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын хэрэгжилт;

- Мэдээллийн ил тод байдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байдал;

- Нийслэлийн удирдлагаас өгсөн цаг үеийн үүрэг даалгавар, түүний гүйцэтгэл.

Тав. Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

5.1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

Үнэлгээний багийн ахлагч:	П.Хадбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.
Гишүүд:	М.Даваабаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтсийн дарга;
	А.Ууганбаяр	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн;
	Ц.Бямбажаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн;
	Г.Халиунаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн;
	М.Намсрайхүү	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газрын мэргэжилтэн;
	Б.Амирлан	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний газрын мэргэжилтэн;
Нарийн бичгийн дарга:	Н.Дэлгэрмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогч.
	С.Болдоо	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн.

5.2. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч Агентлагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

Үнэлгээний багийн ахлагч:	Б.Мөнхбаяр	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга.
Гишүүд:	Г.Ариунтунгалаг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын хэлтсийн дарга;

	Г.Энхжаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газрын ахлах мэргэжилтэн;
	Т.Мөнгөнцэцэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн;
	Э.Оргилцогцлох	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн;
	Ч.Цэрэннадмид	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн;
	Э.Навчаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газрын мэргэжилтэн.
Нарийн бичгийн дарга:	О.Мандах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн.

5.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

Үнэлгээний багийн ахлагч:	Ү.Ганболд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга.
Гишүүд:	А.Эрдэнэмөнх	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн;
	Г.Буянбилэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газрын мэргэжилтэн;
	Б.Норжинлхам	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн;
	Э.Буянмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын мэргэжилтэн;
	С.Дэнсмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга: Р.Энх-Ирээдүй Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн.

5.4.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

Үнэлгээний багийн ахлагч:	Ш.Анхмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газрын дарга.
Гишүүд:	Э.Баясгалан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын газрын Ахлах мэргэжилтэн;
	Д.Оюунжаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн;
	Р.Жамбалсүрэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газрын мэргэжилтэн;
	Г.Үйтүмэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын мэргэжилтэн;
	Н.Оюунбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын мэргэжилтэн.
Нарийн бичгийн дарга:	Т.Хүрэлбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн.

5.5.Төслийн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

Үнэлгээний багийн ахлагч:	Б.Гантулга	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.
Гишүүд:	Б.Амирлан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч;
	Э.Уянга	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн;
	Б.Хүчитбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын мэргэжилтэн;

	Я.Оюунсүрэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн;
	Б.Туяацэцэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын Ахлах мэргэжилтэн.
Нарийн бичгийн дарга:	М.Гачмаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн.

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлтүүд		Хувь
1	2	3
Бодлогын үр дүн	1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан: (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 3.7-д заасан аргачлалаар тооцно.) -Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт; -Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр; -Нийслэлийн хөгжлийн тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилт.	0-100
	2. Нийслэлийн Засаг дарга болон дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан "Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ"-ний хэрэгжилт, үр дүн; (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	3. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт; (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 6.3-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	4. Улс, Нийслэл, Дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн	0-100
	5. Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;	0-100
	6. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	1. Байгууллагын "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний хэрэгжилт, үр дүн: (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт;	0-100
	3. Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал;	0-100
	4. Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаа, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх түүний хэрэгжилт;	0-100
	5. Төсвийн орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөвт олгож буй санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;	0-100

	6. Байгууллагын үйл ажиллагааны зардал бууруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил;	0-100
	7. Санхүүгийн аудитын дүгнэлт, түүний хэрэгжилт;	0-100
	8. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлт;	0-100
	9. Нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй ажлын үр дүн: - Боловсрол, хөдөлмөр эрхлэлт; - Эрүүл мэнд; - Гэр бүл, хүүхэд, залуучууд; - Соёл урлаг;	0-100
	10. Хүнс, худалдаа үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлж буй ажлын үр дүн: - Хүнс, хангамж, хөдөө аж ахуй; - Хоол, үйлдвэрлэл; - Худалдаа үйлчилгээ; - Бусад үйлчилгээ;	0-100
	11. Хот, нийтийн аж ахуйн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын үр дүн: - Хог, хаягдал, цэвэрлэгээ, тээвэрлэлт; - Дэд бүтэц, тохижилт; - Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх; - Бусад;	0-100
	12. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;	0-100
	13. Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүн;	0-100
	14. Газар зохион байгуулалт, газар чөлөөлөлтийн ажлын үр дүн;	0-100
	15. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;	0-100
	16. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал;	0-100
	17. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал.	0-100
	Хэсгийн дундаж хувь	0-100
Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 1.1 Байгууллагын стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; 1.2 Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; 1.3 Үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; 1.4 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; 1.5 Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт.	0-100
	2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 2.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; 2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; 2.3. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам;	0-100

	2.4. Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм.	
	3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 3.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; 3.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; 3.3. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; 3.4. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; 3.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт.	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Ерөнхий үнэлгээ		

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлтүүд		Хувь
1	2	3
Бодлогын үр дүн	1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан: (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 3.7-д заасан аргачлалаар тооцно.) - Монгол Улсын хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт; - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө; - Монгол Улсын хөгжлийн тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилт; - Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт; - Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр; - Нийслэлийн хөгжлийн тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилт.	0-100
	2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт; (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 6.3-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	3. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан батламж, санамж бичиг, хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, үр дүн;	0-100
	4. Улс, Нийслэл, дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн;	0-100
	5. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;	0-100
	6. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан байгууллагын даргын “Хариуцлагын гэрээ” болон байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн; (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4, 2.5-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	2. Тухайн байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт; Үүнд: - Хэлтэс, нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны хэрэгжилт	0-100

	3. Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилт;	0-100
	4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	0-100
	5. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт;	0-100
	6. Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал;	0-100
	7. Төсвийн орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт;	0-100
	8. Байгууллагын үйл ажиллагааны зардал бууруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил;	0-100
	9. Санхүүгийн аудитын дүгнэлт, түүний хэрэгжилт;	0-100
	10.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт;	0-100
	11. Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;	0-100
	12.Байгууллагын дотоод худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүн	0-100
	13.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;	0-100
	14.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал	0-100
	15.Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал. (улсын үзлэгийн дүн)	0-100
	Хэсгийн дундаж хувь	0-100
Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 1.1. Байгууллагын стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; 1.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; 1.3. Үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; 1.4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; 1.5. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт.	0-100
	2.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 2.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; 2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; 2.3. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам;	0-100

	2.4. Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм.	
	3.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 6.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; 6.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; 6.3. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; 6.4. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; 6.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт.	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Ерөнхий үнэлгээ		

**НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ,
АЖ АХУЙН ТООЦООТ БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Үзүүлэлтүүд		Хувь
1	2	3
Бодлогын үр дүн	1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан: (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 3.7-д заасан аргачлалаар тооцно.) - Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт; - Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр; - Нийслэлийн хөгжлийн тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилт.	0-100
	2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт; (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 6.3-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	3. Улс, Нийслэлийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн;	0-100
	4. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;	0-100
	5. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.	0-100
	Хэсгийн дундаж хувь	0-100
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан байгууллагын даргын “Хариуцлагын гэрээ” болон байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн: (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4, 2.5-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	2. Тухайн байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт. Үүнд: - Хэлтэс, нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны хэрэгжилт;	0-100
	3. Хүний нөөцийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилт;	0-100
	4. Ажилтан, албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, түүний хэрэгжилт;	0-100
	5. Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал;	0-100
	6. Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт; (орлого бүрдүүлэгч байгууллагуудад хамраалтай)	0-100
	7. Байгууллагын үйл ажиллагааны зардал бууруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил;	0-100
	8. Санхүүгийн аудитын дүгнэлт, түүний хэрэгжилт;	0-100

	9. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт;	0-100
	10. Хяналт шалгалтын байгууллагаас өгсөн, санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;	0-100
	11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлсэн ажлын үр дүн;	0-100
	12. Байгууллагын дотоод худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүн;	0-100
	13. Төрийн үйлчилгээ; эг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн	0-100
	14. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал;	0-100
	15. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал. (улсын үзлэгийн дүн)	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 1.1. Байгууллагын стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; 1.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; 1.3. Үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; 1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт.	0-100
	2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 2.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; 2.2. Ажилтан, албан хаагчийг сонгон шалгаруулах журам; 2.3. Ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам; 2.4. Ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм.	0-100
	3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 3.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; 3.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; 3.3. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; 3.4. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; 3.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт.	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Ерөнхий үнэлгээ		

**НИЙСЛЭЛИЙН ТӨСЛИЙН НЭГЖ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Үзүүлэлтүүд		Хувь
1	2	3
Бодлогын үр дүн	1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан: (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 3.7-д заасан аргачлалаар тооцно.) - Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт; - Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр; - Нийслэлийн хөгжлийн тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилт.	0-100
	2.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 6.3-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	3.Улс, Нийслэлийн хөрөнгө оруулалт, зээл тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн	0-100
	4.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт	0-100
	5.Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан байгууллагын даргын “Хариуцлагын гэрээ” болон байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн (Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4, 2.5-д заасан аргачлалаар тооцно.)	0-100
	2. Тухайн байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт;	0-100
	3. Хүний нөөцийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилт;	0-100
	4. Байгууллагын үйл ажиллагааны зардал бууруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил;	0-100
	5. Санхүүгийн аудитын дүгнэлт, түүний хэрэгжилт;	0-100
	6. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт;	0-100
	7. Хяналт шалгалтын байгууллагаас өгсөн, санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;	0-100
	8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлсэн ажлын үр дүн;	0-100
	9. Байгууллагын дотоод худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүн;	0-100
	10. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал. (улсын үзлэгийн дүн)	0-100

Хэсгийн дундаж хувь		0-100
Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: - Байгууллагын стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; - Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; - Үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; - Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт.	0-100
	2.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал: - Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; - Ажилтан, албан хаагчийг сонгон шалгаруулах журам; - Ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. - Ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм;	0-100
	3.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: - Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; - Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; - Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; - Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; - Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт.	0-100
Хэсгийн дундаж хувь		0-100
Ерөнхий үнэлгээ		